



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/302

Өлгий

Дэд зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр 29.1.3 "н" заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3 дахь хэсэг, Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ашигт малтмалын үйл ажиллагаа эрхэлдэг компаниуд болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаар иргэдэд нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ОУИТБС-ын дэд зөвлөлийг дараах бүрэлдхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:  
Гишүүд:

-Засаг даргын орлогч  
-Татварын хэлтсийн дарга  
-Аймаг дахь Байгаль орчны иргэний нийгмийн тэргүүн  
-Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн аймаг дахь салбар зөвлөлийн тэргүүн  
-Баян-Өлгий аймгийн байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн холбооны тэргүүн  
-“СС Монголиа” ХХК-ний төлөөлөл  
-“Юүшэнгминг” ХХК-ний төлөөлөл  
-“Монголиан күүпер майнинг” ХХК-ний төлөөлөл  
-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

2. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн байгаль орчинд өөрчлөлт, байгаль хамгаалах талаар сум, дүүрэгт хүргүүлсэн аж ахуйн нэгжийн жил бүрийн тайлан, байгаль хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувийг хуулийн дагуу сумын тусгай дансанд төвлөрүүлсэн байдал, түүний зарцуулалт, буцаан төлөлтийн байдлыг аж ахуйн нэгж бүрээр гаргаж, дэд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн нийтэд ил тод мэдээлж ажиллахыг дэд зөвлөл /А.Камелият/-д даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн засаг даргын 2013 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 89 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ГЫЛЫМХАН